



“ОЛБОРЛОХ САЛБАРТ ИТХ-ЫН ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ” төслийн тайлан

Төсөл хэрэгжүүлэгч: Дундговь аймгийн Өлзийт сумын
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
Төслийг санхүүжүүлэгч: “Монгол Улсын Төлөөллийн
байгууллагыг бэхжүүлэх нь”
төслийн нэгж

2017 он

Төслийн агуулга

- Төслийн танилцуулга
- Төслийн зорилго
- Төслийн зорилт
- Төслийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаа
- Төслийн баг, бүрэлдэхүүн
- Төслийн үйл ажиллагааны хэрэгжилт
- Төслийн үр дүн, бүтээгдэхүүн, шинэлэг ажил

Төслийн зорилго

Сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалт, хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 32 ААН-ын 36 тусгай зөвшөөрөл бүхий талбайн 16 %-д нь ИТХ-аас тусгай загвар, аргачлал ашиглан хяналт, үнэлгээ хийх, цаашид олборлох салбарын үйл ажиллагаанд тавих хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд хурлын төлөөлөгчдийг чадавхжуулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлсэн болно.

Төслийн зорилт

ИТХ-ын төлөөлөгчид, иргэд:

- Олборлох салбарын хууль тогтоомжийн талаар суурь мэдлэг, мэдээлэлтэй болох
- ИТХ-ын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх арга зүй эзэмших
- Олборлох салбарт хяналт, үнэлгээ хийх тусгай загвар аргачлалыг ашиглах ур чадвартай болох
- ИТХ-аас уул уурхайн компанид хяналт, үнэлгээ хийх журам боловсруулж хэрэгжүүлэх

Төслийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаа


- Хурлын төлөөлөгчдөд зориулсан “ИТХ-аас уул уурхайн салбарт хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх нь” сургалт зохион байгуулж, дадлага ажил хийх
- ИТХ-ын төлөөлөгчид, БИНХ-ын дарга, Засаг дарга нар, багийн иргэдийн төлөөллийн оролцоотой уул уурхайн компаниудын байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтын чиг үүргийг тусгай аргачлалын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 3 компани, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 компанийг сонгон хяналт, үнэлгээ хийж, ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах
- Уул уурхайн ААН-үүдэд хийсэн хяналт, үнэлгээний тайлан, дүгнэлтийг баталгаажуулах, хяналтын ул мөрөөр авах арга хэмжээг төлөвлөх, хяналтын арга зүйг буй болгох зорилгоор 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй малчид, иргэдийн худаг ус, өвөлжөө, хаваржааны солбицол, уурхайн замын сүлжээ, лиценз эзэмшигч ААН-үүдийн талбайн байршил, түүх, соёлын дурсгалт зүйлсийн байршил, ТХГН зэрэг мэдээллийг агуулсан **нэгдсэн систем бүхий олборлох салбарын ил тод байдлын мэдээллийн зураг боловсруулах**

Төслөөс хүлээж байсан үр дүн

- Жижиг, дунд хэмжээний уул уурхайн компанид тогтмол хяналт үнэлгээ хийсэн сайн туршлага, арга зүй, журам гарах
- Сумын газар нутаг дээрх тусгай зөвшөөрлийн лицензийн талбайн байршил, өвөлжөө хаваржаа, худаг ус, түүх дурсгалын газар нутгийг харуулсан мэдээллийн газрын зураг гарсан байх
- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 3 компаныг хамруулан хяналт, үнэлгээ хийж, үнэлгээний тайлан гаргаж, дүгнэлт хийсэн байх

Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

“Олборлох салбарт ИТХ-ын хяналтын чиг үүрэг” төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу Өлзийт сумын ИТХ-аас 2017 оны 7-р сарын 24-25-ны өдрүүдэд сумын иргэдийн хурлын төлөөлөгчид, БИНХ-ын дарга нарыг хамруулан олборлох салбарын хууль тогтоомжийн талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтын хоёр дахь өдөр хурлын төлөөлөгчид тусгай аргачлалын дагуу бэлтгэсэн хяналтын карт ашиглан уул уурхайн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх арга зүй эзэмших **дадлага ажил** хийсэн ба дадлага ажлыг жоншны ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг “Межик бридж” ХХК-ны талбай дээр очиж хийсэн. Дадлага, сургалтыг “Хил хязгааргүй алхам” ТББ-ын сургагч багш Н.Баярсайхан чиглүүлж, Хэнтий аймгийн Мөрөн сумын ИТХ-ын төлөөлөл ирж туршлага судлаж, солилцсон.



Сургалт, дадлага ажлын хөтөлбөр

БАТЛАВ. ИТХ-ын ДАРГА  Х.ОТГОНМӨНХ

2017.07.16

Рашаант
**“ОЛБОРЛОХ САЛБАРТ ИРГЭДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРГЭЭ
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Сургалтын зорилго: НҮБХХ-өөс зохион байгуулж буй тэтгэлэгт төслийн хүрээнд иргэдийн хурлын төлөөлөгчийн олборлох салбарт хяналт хийх мэдлэгийг дээшлүүлэн ААН-д хяналтын дадлага хийлгэж ур чадвар олгоход оршино. Сургалтыг 2017 оны 07-р сарын 24-ны өдрийн 09.⁰⁰ цагаас эхэлж 1,5 өдөрт багтаан явуулна.

Сургалтын зорилт

- ИТХ-ын төлөөлөгчдөөс олборлох салбарт хяналт хийх эрх зүйн болон ОУИТБС-ын талаар мэдлэг олгох сургалтыг мэргэжлийн багшаар өгүүлэх
- “Хил хязгааргүй алхам” ТББ-аас гаргасан аргачлалын дагуу суманд үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын болон хайгуулын ААН-ийг үнэлж, хяналт шинжилгээ хийх аргачлалд сургах

Сургалт зохион байгуулагч: Төсөл хэрэгжүүлэгч баг

Сургалтанд оролцогчид: ИТХ-ын 20 Төлөөлөгч, ИТХ-ын нарийн бичгийн дарга, БИНХ-ын дарга нар

Хаана: Дундговь аймгийн Өлзийт сум

Сургалтын байр: Соёлын төв

24-ны өдөр

09.00-09.20 Тэтгэлэгт төслийн товч танилцуулга, Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн байршил, тухайн талбай дээрх өвөлжөө, хаваржаа, уст цэгийн байдлыг зургаар тайлбарлаж төлөөлөгчдийн саналыг тусгах

ИТХ-ын дарга **Х.ОТГОНМӨНХ**

09.20-09.40 “Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн шинэчилсэн дэлгэрэнгүй бүртгэл, 2016-2017 онд тэдгээрийн хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан”

Засаг дарга **И. ЭРДЭНЭБИЛЭГ**

09.40-10.00 Тусгай зөвшөөрөл бүхий талбай дээр байршилтай түүх, соёлын дурсгалын байршил, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт

Соёлын төвийн эрхлэгч **Ц.ХАДХҮҮ**

10.00-11.00 “Эрдэс баялагийн салбарын эрх зүйн зохицуулалт, төрийн бодлого, Олборлох салбарт ИТХ-аас хяналт тавих арга зүй”

“Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн **Н.БАЯРСАЙХАН**

11.00-11.10 Цайны завсарлага

11.10-13.00 “Эрдэс баялагийн салбарын эрх зүйн зохицуулалт, төрийн бодлого, Олборлох салбарт ИТХ-аас хяналт тавих арга зүй” ҮРГЭЛЖЛЭЛ

“Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн **Н.БАЯРСАЙХАН**

13.00-14.00 Үдийн хоол

14.00-17.00 Жоншны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Мэжикбридж” ХХК-ны үйл ажиллагаатай танилцаж, хяналтын дадлага хийх

25-ны өдөр

09.00-10.00 “Үнэлгээ хийх аргачлал, хяналтын картын дагуу хийсэн хяналтын үр дүн, дараагийн хяналтанд анхаарах асуудлууд”
Төсөл хэрэгжүүлэгч багийн гишүүн **Ж.НАРАНЖАВ**

11.00-11.10 Цайны завсарлага

11.10-12.00 Асуулт, хариулт, ярилцлага

12.00-12.10 Хаалт

ИТХ-ын дарга **Х.ОТГОНМӨНХ**

12.10-13.00 Үдийн хоол

“Межик бридж” ХХК дээр хийсэн дээрх хяналт, үнэлгээг 1-3 хүртэл оноогоор дүгнэх хяналтын картаар дүгнэж үзэхэд нэгдсэн үнэлгээгээр 3 оноо авахаас 2,7 оноогоор дүгнэгдсэн байна.

“МЕЖИКБРИДЖ”ХХК-ЫГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ КАРТЫН НЭГТГЭЛ

	Компани дээр байх ёстой, олон нийтэд нээлттэй үзүүлэх үүрэгтэй баримт бичиг,Төлөөлөгчдөд өгөх мэдээлэл	Ашиглах мэдээллийн эх сурвалж	Хяналтын тэмдэглэл
А. Компаны кемп дээр очиж үзэх боломжтой баримт бичгүүд, шалгах асуултуудтай холбоотой хуулийн заалтууд			
1.	АМТХ. 25-р зүйлийн 25.1.6. Хайгуулын ажлын явцад БО-ны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай дүгнэлт	Аймгийн МХГ-ийн дүгнэлтийг бодит байдалтай нийцүүлэн харах, актын огноог харах	3
2.	АМТХ. 34-р зүйлийн 34.1. Лиценз авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлсөн эсэх	Төлбөрийн баримт огноог харах	3
3.	АМТХ. 17-р зүйлийн 17.3.3. Тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газартай давхцаагүй эсэх	Газрын нэрээр асуух, солбицлолыг лавлаж харах	3
4.	АМТХ. 17-р зүйлийн 17.4.Лицензийн нийт талбайн хэмжээ 25 га-аас их, 150 га-аас бага байгаа эсэх	Лицензийн гэрчилгээнээс харах	0
5.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.1.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар	Хуулбар огноог харж лицензийн хугацаандаа байгаа эсэхийг харах	3
6.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.2.Батлагдсан техник, эдийн засгийн үндэслэл болон АМГТГ-аар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө	Төлөвлөгөө түүнийг баталсан огноо	3
7.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.3.Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, Нэмэлт тодотгол хийсэн бол нэмэлт тайлан	Үнэлгээ хийсэн компани, огноо	3
8.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.4БОАЖ-аар батлуулсан БОМТөлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө тайлан.	Батлагдсан огноо түүний хэрэгжилт бодит байдал дээр	3
9.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.6.Уурхайн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан акт	Шав тэмдэг тавьсан акт болон бодит байдал дээр ямар байгааг үзэх	3
10.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.7.Сумын Засаг даргатай байгуулсан ус, газар ашиглах гэрээ	Гэрээ, байгуулсан огноо, хүлээсэн үүргийн биелэлт	2.7
11.	АМТХ. 42-р зүйлийн 42.1.Нутгийн Захиргааны байгууллагатай Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан эсэх.Уг гэрээг олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх	Гэрээ түүний хэрэгжилт, иргэдийн оролцоо хангасан эсэх	2.5
12.	АМТХ. 43-р зүйлийн 43.1.Компанийн нийт ажиллагсад.....үүнээс.....гадаадын иргэд хэд байгаа	90%-аас дээш давсан эсэх түүний төлбөрийг суманд төлсөн эсэх	0
13.	АМТХ. 39-р зүйлийн 39.1.9.Тухайн жилийн нөхөн сэргээлтийн зардлын 50%-ийг БОАЖЯ-ны тусгай дансанд хийсэн төлбөрийн баримт, эргүүлэн авсан эсэх	Төлбөрийн баримтын хуулбар огноо харах	3
14.	АМТХ. 41-р зүйлийн 41.1.1.Ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлд гэм хор учруулсан бол хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн	Бодит байдал, иргэдийн мэдээлэлтэй харьцуулж нягтлах	2.8
15.	АМТХ. 69-р зүйлийн 39.1.7. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөлийг тухай бүр бүртгэж,байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний тайланг сумын Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлсэн	Бодит байдал Засаг даргад танилцуулсан баримтуудыг үзэх түүнд Засаг даргын өгсөн хариу	2.5

баримт бүртгэл			
16.	АМТХ. 48-р зүйлийн 48.10.Тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет бус хандивын хэмжээг олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж	Олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж мэдээлсэн, хандив тусламж хэд хэнд өгсөн, ямар дансанд орсон, баталгаажуулсан байдал	2.8
17.	БОНБУТХ. 18-р зүйлийн 18.4.Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.	БОНБНУ-ний тайлангаас Санал хэрхэн авсан, хэлэлцүүлэгээс ямар санал гарсан тайланд хэрхэн тусгасан байдлыг харна.	1.8
18.	БОНБУТХ. 14-р зүйлийн 14.1.2. байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах	Хэрэгжилтийг тайлан, түүнийг олон нийтэд хэрхэн танилцуулсантай тулгаж он оноор үзэх	1.5
19.	ГТХ.5-р зүйлийн 51.2.Төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан,агаар,ой,ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах зөвшөөрөл	Хэрэгжилтийг газар дээр нь нарийвчлан үзэх	3
20.	УТХ.30 дугаар зүйл.Ус ашигласны болон бохирдуулсны төлбөр төлсөн баримт жил бүрээр	Төлбөрийн баримт бичиг	3
21.	ГХТХ.8-р зүйлийн 8.1.4./ашигт малтмалын ордыг ашиглах үед үржил шимтэй хөрсийг тусгайлан хуулж ашиглах буюу хадгалсан байх	Засаг даргатай байгуулсан газар ашиглах гэрээнд хэрхэн тусгасан бодит байдал	3
22.	ГХТХ.32-р зүйлийн 32.8.ажиллагчид болон хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлий, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөө байгаа эсэх, батлуулсан огноо	Төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг үзэх	2.5
23.	БОХТХ.31-р зүйлийн 31.4.байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг ААН, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх	Тусгасан төсвийн зарцуулалт нөхөн сэргээлтийн үр дүнтэй харьцуулан үзэх	3
24.	БОХТХ.49-р зүйлийн 48.1. Иргэн ААН, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлнө.	Байгаль хамгаалагч төлбөр тавьсан бол түүнийг төлсөн төлбөрийн баримт огноо	0
25.	БОХТХ.55-р зүйлийн 55.2.2.Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан болон зөвшөөрөлгүй агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хог хаягдал, бусад бодис гаргахад нөхөн төлбөр ногдуулна.	Хэтрүүлсэн хог хаягдал, бусад бодис гаргасныг ажиглах,түүний хэтрэлтэд БОУ-ын байцаагчийн хяналт төлбөрийн баримт бичиг	2.8
26.	Ажилчдын эрх ашгийг хамгаалах Үйлдвэрчний эвлэл байдаг эсэх, түүний үйл ажиллагаатай танилцах	Ажилчдаас мэдээлэл авах	1
27.	ТХШТХ-ийн 7.2. ААН, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 311 тогтоолын дагуу Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг эсэх, хариуцсан ажилтан байгаа эсэх	Дотоод журам үзэх, ажилтантай уулзах	1.4
28.	ГХТХ. Газрын хэвлийг ашиглах явцад илэрсэн түүх, соёлын онцгой үнэт зүйл, олдворыг зохих байгууллагад мэдэгдсэн	Асуулт хариултаар мэдээлэл авах	0
В. Тухайн компанитай холбоотой мэдээллийг ЗДТГ түүний холбогдох албан тушаалтанд асуулга, асуулт			

Үнэлгээний нэгтгэл 2,7 оноо

Хяналт үнэлгээний дадлага, сургалтын тэмдэглэл

Дундговь аймгийн Өлзийт сумын 4-р багийн нутаг дахь ашиглалтын лицензтэй “Межикбридж” ХХК-ны үйл ажиллагаанд хяналт үнэлгээний дадлага хийсэн тэмдэглэл

2017-07-25

Дугаар

Говийн хөх

2017 оны 07 сарын 25-ны өдөр сумын ИТХ-ын төлөөлөгч, сумын удирдлагууд оролцсон 15 хүн “Межикбридж” ХХК-ны кемп дээр очиж Х.Отгонмөнх удирдамж танилцуулав. Тусгай боловсруулсан картыг 15 төлөөлөгчид тараан өгч хяналт үнэлгээг асууж тайлбар сонсох байдлаар үнэлэв. Төлөөлөгчдийн үнэлсэн үнэлгээг нэгтгэж нэгдсэн үнэлгээг гаргаж дундаж үнэлгээг 83.3 буюу 2.5 байлаа. Үнэлгээг 1-3 оноогоор өглөө. Төлөөлөгчид бичиг баримтуудтай нэг бүрчлэн танилцав.

Төлөөлөгчид уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж асуулт асууж хариулт авлаа.

Төлөөлөгч О.Ган-Бид уул уурхайн асуудлыг мэдэхгүй. Ямар журмаар юу хийдгийг мэдэхгүй. Энэ дадлагаар уул уурхай ямар үйл ажиллагааг яаж явуулдагийг мэдлээ.


Төлөөлөгч Буд-Очир-Маш их бичиг баримт, зөвшөөрөл бүрдүүлдэг юм байна. Урьд нь орон нутгаас төлөөлөгчдөөс хяналт тэвжж байгаагүй. Хянах эрхтэй юм байна. Энэ хяналтын картгүй бол яаж үнэлхээ мэдэхгүй юм байна. Ач холбогдол сайтай дадлага боллоо.

Төлөөлөгч Мөнхцэцэг-картаар бусад уурхайн ААН-г хянаж чадах юм байна. Аль альдаа ашигтай байх. Хяналтын тодорхой журам байх шаардлагатай.

Х.Отгонмөнх-Журам боловсруулъяа. Хяналтыг багаар удирдамжаар хийе. Ж.Наранжав-Үнэлгээний картыг холбогдох хуулийн заалтаар хийсэн нь мэргэжлийн бус хүмүүс үнэлгээ хийхэд тохиромжтой байна. Хяналт үнэлгээ хийх журмын төсөл болвсруулж ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлцүүлъяе.

Хяналт үнэлгээний дадлагын үр дүн:

1. Төлөөлөгчид уул уурхайн зохих мэдлэгтэй болсон
2. Хяналт үнэлгээ нь уул уурхайн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ач холбогдолтой байна.
3. Цаашид үргэлжүүлэх боломжтой
4. Төлөөлөгчид хяналт үнэлгээний дадлагатай боллоо гэж дүгнэлээ.

Тэмдэглэл хөтөлсөн: Газрын даамал  Бүжинлхам



2017 оны 10-р сарын 27-нд ИТХ-ын төлөөлөгчид, 1, 2-р багийн ИНХ-ын дарга нар байгаль орчны талаарх зөрчил дутагдлыг тодорхойлж арилгах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, АМТ болон БО-ны хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэх зорилго бүхий тусгай удирдамжаар тус сумын 2-р багийн нутаг Буянт багийн төвийн ойролцоо байх ураны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Гурвансайхан”

ХХК-ны үйл ажиллагаатай танилцаж, тусгай аргачлалын дагуу гаргасан хяналтын картаар хяналт, үнэлгээ хийлээ. Үнэлгээг 0-3 оноогоор үнэлэн нийт 14 хүн хийж дундаж үнэлгээгээр дүнг тооцоход Гурвансайхан ХХК-ны баримт бичгийн бүрдэл, үйл ажиллагааны үнэлгээ 2,1 буюу дундаж үнэлэгдлээ.



Үнэлгээ хийсний дараа ураныг ямар технологиор хэрхэн олборлох, цаашид ямар бодлого баримтлах гэх зэрэг асуудлуудаар хэлэлцүүлэг явуулж компаны гүйцэтгэх захирал н.Бат-Очироос хариулт авлаа. Хэлэлцүүлгээс гарсан шийдвэр: 1, 2-р багийн ИНХ-д Гурвансайхан ХХК дэлгэрэнгүй танилцуулга хийж, иргэдийн санал авахаар шийдвэрлэлээ.

Хяналт, үнэлгээ, хэлэлцүүлгийн үйл явцыг архивын нэгж болгон хадгалах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бэлтгэх зорилгоор видео бичлэг хийж баримтжуулсан.

Энэ удаагийн хяналт үнэлгээний ажилд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Их монгол коммерс” ХХК, “Өгөөмөр говийн нуур” ХХК-иуд хамрагдах байсан боловч үнэлгээ хийх хугацаанд ирээгүй болно. Хяналт, үнэлгээ хийх ажлын удирдамж хавсаргав.

Хяналт, үнэлгээ хийх ажлын удирдамж

ИТХ-ЫН ДАРГА

БАТЛАВ.ӨЛЗИЙТ СУМЫН

Х.ОТГОНМӨНХ

**Дундговь аймгийн Өлзийт суманд бүртгэлтэй
уул уурхайн компаниудад хийх хяналт, үнэлгээний
ажлын удирдамж**

2017.10.23

Рашаант

Зорилго: Өлзийт сумын нутаг дэвсгэрт бүртгэлтэй ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүдийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх замаар байгаль орчны чиглэлийн зөрчил, дутагдал, эрсдлээс урьдчилан сэргийлэх, ашигт малтмалын тухай хууль, байгаль орчны талаарх хууль, тогтоомжуудыг дагаж мөрдүүлэхэд оршино.

Хамрагдах ААН-үүд: “Гурвансайхан” ХХК, “Өгөөмөр говийн нуур” ХХК, “Их монгол коммерс” ХХК

Хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэг: Сумын ИТХ-ын төлөөлөгчид, 1, 2-р багийн ИНХ-ын дарга нар.

Хяналт, үнэлгээ хийх хугацаа: 2017 оны 10-р сарын 27-ны өдөр.

Хяналт, үнэлгээ хийх газар: Буянт багийн төвд “Гурвансайхан” ХХК-ы кемп, “Их монгол коммерс” ХХК, “Өгөөмөр говийн нуур” ХХК-ны хайгуулын талбайд

Хяналт, үнэлгээ хийх хэлбэр:

- Ажлын хэсгийн гишүүд /иргэдийн хурлын төлөөлөгч нар/ тусгайлан бэлтгэсэн хяналтын хуудас бөглөх журмаар тухайн компани ажлын байран дээр АМТ хуулийн дагуу байвал зохих баримт бичгийн бүрдлийг үзэх
- Үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдалтай танилцаж, цаашдын ажлын төлөвлөгөөг үзэх
- Хяналтын карт бөглөж үнэлгээний дүнг нэгтгэн гаргаж, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар уул уурхайн компаниудын үйл ажиллагаатай холбогдох дүгнэлт гарган Засаг даргад чиглэл өгөх

Өлзийт сумын

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Үнэлгээний карт

Ураны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Гурвансайхан” ТӨХК нь тус суманд 2006 оноос хайгуулын үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 2016 оны 9-р сард Ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан. Одоогоор ашиглалт явуулж эхлээгүй байгаа учраас үнэлгээний карт дахь зарим заалтуудыг үнэлэх боломжгүй гарсан. Боломжтой заалтуудыг тооцож доорх үнэлэхэд 3 оноо авахаас 2,1 оноотой үнэлэгдсэн болно.

2017.10.27		Өлзийт сум	
Компани дээр байх ёстой, олон нийтэд нээлттэй үзүүлэх үүрэгтэй баримт бичиг,Төлөөлөгчдөд өгөх мэдээлэл		Ашиглах мэдээллийн эх сурвалж	Хяналтын тэмдэглэл
А. Компани кемп дээр очиж үзэх боломжтой баримт бичгүүд, шалгах асуултуудтай холбоотой хуулийн заалтууд			
1.	АМТХ. 25-р зүйлийн 25.1.6. Хайгуулын ажлын явцад БО-ны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай дүгнэлт	Аймгийн МХГ-ийн дүгнэлтийг бодит байдалтай нийцүүлэн харах, актын огноог харах	39 / 2,9
2.	АМТХ. 34-р зүйлийн 34.1. Лиценз авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлсөн эсэх	Төлбөрийн баримт огноог харах	29 / 2
3.	АМТХ. 17-р зүйлийн 17.3.3. Тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газартай давхцаагүй эсэх	Газрын нэрээр асуух, солбицлолыг лавлаж харах	42 / 3
4.	АМТХ. 17-р зүйлийн 17.4 Лицензийн нийт талбайн хэмжээ 25 га-аас их, 150 га-аас бага байгаа эсэх	Лицензийн гэрчилгээнээс харах	=
5.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.1.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар	Хуулбар огноог харж лицензийн хугацаандаа байгаа эсэхийг харах	21 / 15
6.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.2.Батлагдсан техник, эдийн засгийн үндэслэл болон АМГТГ-аар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө	Төлөвлөгөө түүнийг баталсан огноо	29 / 2
7.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.3.Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, Нэмэлт үнэлгээний мэдээлэл	Үнэлгээ хийсэн компани, огноо	39 / 2,7
8.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.4.БОАЖ-аар батлуулсан БОМТөлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө тайлан.	Батлагдсан огноо түүний хэрэгжилт бодит байдал дээр	31 / 2,2
9.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.6.Уурхайн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан акт	Шав тэмдэг тавьсан акт болон бодит байдал дээр ямар байгааг үзэх	35 / 2,5
10.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.7.Сумын Засаг даргатай байгуулсан ус, газар ашиглах гэрээ	Гэрээ, байгуулсан огноо, хүлээсэн үүргийн биелэлт	22 / 2,2
11.	АМТХ. 42-р зүйлийн 42.1.Нутгийн Зөхиргааны байгууллагатай Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан эсэх.Уг гэрээг олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх	Гэрээ түүний хэрэгжилт, иргэдийн оролцоо хангасан эсэх	17 / 1,2
12.	АМТХ. 43-р зүйлийн 43.1.Компанийн нийт ажиллагсад.....үүнээс.....гадаадын иргэд хэд байгаа	90%-аас дээш дэвшсэн эсэх түүний төлбөрийг суманд төлсөн эсэх	
13.	АМТХ. 39-р зүйлийн 39.1.9.Тухайн жилийн нөхөн сэргээлтийн зардлын 50%-ийг БОАЖЯ-ны тусгай дансанд хийсэн төлбөрийн баримт, зргүүлэн авсан эсэх	Төлбөрийн баримтын хуулбар огноо харах	
14.	АМТХ. 41-р зүйлийн 41.1.1.Ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлд гэм хор учруулсан бол хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн	Бодит байдал, иргэдийн мэдээлэлтэй харьцуулж нягтлах	
15.	АМТХ. 69-р зүйлийн 39.1.7. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөлийг тухай бүр бүртгэж,байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний тайланг сумын Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлсэн баримт бүртгэл	Бодит байдал Засаг даргад танилцуулсан баримтуудыг үзэх түүнд Засаг даргын өгсөн хариу	
16.	АМТХ. 48-р зүйлийн 48.10.Тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет	Олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж мэдээлсэн, хандив тусламж хэд хэнд өгсөн, ямар	21 / 1,5

1д заасан - 36 оноо
нийт 25,5 - 2,1 багц

Хэлэлцүүлгийн тэмдэглэл

Дундговь аймгийн Өлзийт сумын Буянт багийн нутагт Ашиглалтын лицензтэй “Гурвансайхан”ХХК-ны удирдлага, сумын ИТХ-ын Төлөөлөгч нарын хамтарсан ярилцлага, хэлэлцүүлгийн тэмдэглэл

2017-10-27

Дугаар

Буянт

Сумын ИТХ-ын дарга Х.Отгонмөнх- Уул уурхайн компаниудад хийх хяналт шинжилгээний ажлын удирдамжийг танилцуулав.

“Гурвансайхан”ХХК-ны захирал Бат-Очир компаны товч танилцуулга,үүсэл хөгжил, үйл ажиллагааны талаар яриу.Компаны үйл ажиллагаа өнөөгийн хувьд зогсож хөрөнгө оруулагч хүлээж байна.Хайрханы талбайд 86.8 мянган метр өрөмдлөг хийсэн.8400тн ураны нөөц тогтоосон.

Төлөөлөгч Н.Цэвэгмэд-Энд хайгуул хийхийн тулд хичнээн төгрөг зарцуулсан вэ?

Бат –Очир-2008 оны байдлаар 9466000 доллар зарцуулсан.

Ж.Наранжав-Ашиглалтын лицензтэй компаныг үнэлэх үнэлгээ хийх карт бөглөнө.Хууль ёсны дагуу бичиг баримтаа бүрдүүлсэн эсэхэд хяналт үнэлгээ хийх зорилготой. Бэлчээр ус бохирдох, өвөлжөө, хаваржаа сүйтгэсэн эсэх эргэн засаж сэлбэж өгсөө сэхэд хяналт хийх санал асуулга авсан.

Бат-Очир-Уснаас болж ямаа үхсэн гэсэн яриа гарсан. 2005 онд гарсан. Хортой бодис хэрэглэж байгаагүй.Уран бол цацраг яригддаг.Уран цацраг багатай дагаж байгаа бодисууд цацраг ихтэй байх магадлалтай.Цацрагийн хамгаалалтыг хангаж ажиллах шаардлагатай байдаг.

ИТХ-ын дарга Х.Отгонмөнх-Хяналт үнэлгээг хийлээ. Дундаж үнэлгээ 2.7 оноотой байна. Цаашид ашиглалт эхэлсэн тохиолдолд хяналт үнэлгээний картыг цөмийн энергийн талаас нь гаргаж дахин хяналт хийгдэнэ.

Асуулт: 1.Ашиглалт эхлэхэд ямар технологи аль улсын техник технологи ашиглах вэ?

2. Ураны хэрэгцээ хэр байдаг вэ?
3. Уран их ашиглагдаад ирвэл ус их орох уу?
4. Шар нунтагийг тайлбарлана уу.

Захирал Бат-Очир-Газар дор уусгах технологи гэж байна.Газрын дор усны сүлжээтэй газраар уусмал уусах тарах магадлалтай.Дэлхийн уран олборлолтын 50 хувь нь энэ технологигоор олборлож байна. Газар хөнддөггүй учир байгальд ээлтэй

гэж үздэг.Энэ төсөл 140сая долларын өртөгтэй.Бидний хийсэн судалгаагаар аймаг улсаас төсөв авахгүй болно. 12 сая долларын татвар төлөх магадлалтай.Манай гаргасан бүтээгдхүүнийг Чех авна. Энгийн зориулалттай Чех 2 цахилгаан станцтай.Үйлдвэр өөрөө тийм том биш 150-160 хүн ажиллана.Үйлчилгээ, харуул хамгаалалтын ажилтан нийт 300 гаруй хүн ажиллана. Орон нутгаас 50 хувь ажилчин авах боломжтой.

Төлөөлөгч Алтанцэцэг-Айл өрхийг нүлгэх үү? Мал аж ахуй байж болох уу?

Бат-Очир- болно. Ямарч нүүлгэлт байхгүй.

Тэмдэглэл хөтөлсөн:

М.Нарангарав



ИТХ-ЫН ДАРГА БАТЛАВ ӨЛЗИЙТ СУМЫН
Х.ОТГОНМӨНХ

**Дундговь аймгийн Өлзийт суманд бүртгэлтэй
уул уурхайн компаниудад хийх хяналт, үнэлгээний
ажлын удирдамж**

2017.11.27 Рашаант

Зорилго: Өлзийт сумын нутаг дэвсгэрт бүртгэлтэй ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүдийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх замаар байгаль орчны чиглэлийн зөрчил, дутагдал, эрсдлээс урьдчилан сэргийлэх, ашигт малтмалын тухай хууль, байгаль орчны талаарх хууль, тогтоомжуудыг дагаж мөрдүүлэхэд оршино.

Хамрагдах ААН-үүд: “Билэгт хайрхан уул” ХХК, “Алкали метал монголиа” ХХК,

Хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэг: Сумын ИТХ-ын төлөөлөгчид, 1, 2-р багийн ИНХ-ын дарга нар.

Хяналт, үнэлгээ хийх хугацаа: 2017 оны 11-р сарын 27-ны өдөр.

Хяналт, үнэлгээ хийх газар: Буянт багийн “Алкали метал монголиа” ХХК-ны талбай

Хяналт, үнэлгээ хийх хэлбэр:

- Ажлын хэсгийн гишүүд /иргэдийн хурлын төлөөлөгч нар/ тусгайлан бэлтгэсэн хяналтын хуудас бөглөх журмаар тухайн компаны ажлын байран дээр АМТ хуулийн дагуу байвал зохих баримт бичгийн бүрдлийг үзэх
- Үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдалтай танилцаж, цаашдын ажлын төлөвлөгөөг үзэх
- Хяналтын карт бөглөж үнэлгээний дүнг нэгтгэн гаргаж, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар уул уурхайн компаниудын үйл ажиллагаатай холбогдох дүгнэлт гарган Засаг даргад чиглэл өгөх

Төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу 2017 оны 11-р сарын 27-ний өдөр удирдамжийн дагуу ИТХ-ын төлөөлөгчид, 1,2,5-р багийн ИНХ-ын дарга нарын 14 хүний бүрэлдэхүүнтэй явж 1, 2, 5-р багийн нутагт байрлах ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Билэгт хайрхан уул” ХХК, “Алкали метал монголиа” ХХК-уудын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийлээ. Тус компаниуд нь ашиглалтын тусгай зөвшөөрлөө 2009-2013 онд авсан боловч хөрөнгө, санхүүгийн шалтгааны улмаас ашиглалтын үйл ажиллагаагаа эхлүүлээгүй, бэлтгэл үе шатандаа явж байгаа тухай компаний төлөөлөл танилцуулсан. Дээрх компаниудад хяналт үнэлгээ

хийх талаар ИТХ-ын ажлын албанаас урьдчилж албан бичиг хүргүүлсэн. Хяналт, үнэлгээ хийхээр очиход компаниудын ЭБАТ нь ирээгүй, компаны төлөөллөө явуулсан ч хангалттай бичиг баримтын бүрдэлгүй байсан учраас бодит үнэлгээ хийх боломжгүй байсан тул холбогдох баримт бичгүүдийг 2018 оны 3-р сард зохион байгуулах нээлттэй хэлэлцүүлэг дээр бүрэн авчирч үнэлгээ хийлгүүлэх тухай албан шаардлага өглөө.



Хэлэлцүүлгийн тэмдэглэл, гарсан шийдвэр

Хэлэлцүүлт оролцогчдоос ИТХ-ын хяналт, үнэлгээ хийж байгаа энэхүү үйл ажиллагааг цаашид тогтмол хийж, компаниудын хариуцлагыг сайжруулах, хариуцлагатай уул уурхайг сумандаа хөгжүүлэх үндэслэл болгох зорилгоор уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, компаниудад хяналт, үнэлгээ хийх журам баталж хэрэгжүүлэх санал гаргаж, журмын бүтцийг хэлэлцлээ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Билэгт хайрхан уул”ХХК, “Алкали метал монголиа”ХХК-ны үйд ажиллагаанд хяналт үнэлгээ, хэлэлцүүлэг хийсэн тухай тэмдэглэл

2017-11-27

Дугаар

Рашаант

Хяналт үнэлгээний хэлэлцүүлэгийг 2017 оны 11-р сарын 27-ны өдрийн 17 цагт ЗДТГ-ын зааланд эхлэв. Хэлэлцүүлэгт сумын хурлын төлөөлөгчид, иргэдийн төлөөлөл, 2 компани менежер, геологчид оролцов.

Танилцуулсан нь: Х.Отгонмөнх-Буянт багийн “Тоодог” хэмээх газарт байгаа “Алкали метал монголиа”ХХК-ны талбай дээр төлөөлөгчид очиж картын дагуу үнэлгээ хийсэн боловч бичиг баримт дутуугаас бодит үнэлгээг гарах боломжгүй байлаа.

Хэлэлцсэн нь:

Геологич Даваа/Алкали металли монголиа/-Манайх ашиглалтын лицензээ авсан боловч хөрөнгийн асуудлаас болоод үйл ажиллагаа явуулаагүй байгаа.Ийм учраас хяналтын картын ихэнх асуултуудад хариулт байхгүй байна.Үлдсэн баримт бичгүүдийг 2018 оны 3 сард болох хэлэлцүүлэг дээр авчирч нийтэд танилцуулъяа.

Т.Алтанцэцэг/1-р багийн БИНХ-ын дарга/-Ашиглалт авахад ямар баримт бүрдүүлсэн, хэзээ үйл ажиллагаа эхлүүлэх талаар дээрх 2 компани багийн иргэдийн нийтийн хурал дээр тайлагнах хэрэгтэй байна.

Т.Отгонтоогоо/2-р багийн БИНХ-ын дарга/-Би бас ийм санал тавьж байна. БИНХ дээр эрх мэдэл бүхий хүнээ ирүүлэх хэрэгтэй.

П.Алтанцэцэг/Төлөөлөгч/-Үйл ажиллагааныхаа талаар дарга нарт мэдэгдээд, иргэдтэй уулздаггүй, малчин айл өрхөөр орж танилцуулгаа хийж байх нь зүйтэй.

Галсандагва/Билэгт хайрхан уул-менежер/-Манайх бас үйл ажиллагаа явуулж чадаагүй байгаа.БИНХ-д танилцуулгаа хийхэд болно хүлээж авч байна.

О.Буд-Очир/төлөөлөгч/-Энэ компаниуд хэзээ ашиглалт явуулах юм вэ? Орон нутагт төлдөг төлбөрөө төлдөг үү?

Даваа-өнгөрсөн хаврын хэлэлцүүлэг дээр төлсөн төлбөрөө тайлагнасан.

Галсандагва-газар,усны төлбөрөө төлсөн байгаа. Татварын байцаагч чинь мэднэ.

Айлтгүй/төлөөлөгч/-хөдөө талбай дээр асуух зүйлээ асууцгаасан.Бид хяналт хийх журам гаргаж түүнийхээ дагуу төлөвлөгөөт хяналтаа цаашид хийж байя.Энэ

хөтөлбөр маш их зүйл мэдүүлсэн арга хэмжээ боллоо.Энэ саналыг оролцогчид дэмжлээ.

Х.Отгонмөнх-Одоо хэлэлцүүлгийн үр дүнд гарах шийдвэрээ ярилцая.

Шийдвэрлэсэн нь: 1.Хяналт, үнэлгээ хийх журам гаргаж мөрдөх


2. Дээрх 2 компани бичиг баримт дутуугаас бодит үнэлгээ хийх боломжгүй тул 2017 оны 3 сард болох хэлэлцүүлэгт бичиг баримтаа бүрэн авч ирж хяналт үнэлгээгээ хийлгэх

3. Ашиглалтын компаниуд БИНХ-ууд дээр оролцож мэдээллээ хийж байхаар тогтлоо.

Тэмдэглэл хөтөлсөн:  Ж.Наранжав

“Олборлох салбарын ил тод байдлын мэдээллийн зураг” боловсруулав

ДУНГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ ЛИЦЕНЗИЙН ТАЛБАЙН ЗУРАГ



Суманд бүртгэлтэй лиценз эзэмшигч компаниудын талбайн байршил, улсын болон ОНТХ-д авсан газар нутгийн байршил, бүх өвөлжөө хаваржаа, худаг уст цэг, түүх соёлын дурсгалт зүйлсийн байршлуудыг тодорхойлсон **“Олборлох салбарын ил тод байдлын мэдээллийн зураг”**-ийг боловсруулав. Тус зургийг боловсруулахад зарим багийн худаг ус, айлын өвөлжөө, хаваржаа, түүх соёлын дурсгалт зүйл, хийдийн туурь зэргийн байршлын координат тодорхойгүй байсныг соёлын төвийн эрхлэгч, багийн Засаг дарга

нар, байгаль хамгаалагч зэрэг албан хаагчдыг явуулж байршлыг тодорхойлуулсан.


Төслийн багийн бүрэлдэхүүн

№	Овог нэр	Ажил, албан тушаал	Тэтгэлэгт гүйцэтгэх ажил, үүрэг	Холбоо барих утас, хаяг, мэйл
1	Х.Отгонмөнх	ИТХ-ын дарга	Багийн удирдлага, зохион байгуулалтаар ханган, төслийн явцад хяналт хурал хуралдуулах, шийдвэр гаргах, санхүү хариуцна.	88022955 otgonmunh_h@yahoo.com otgonmunh55@gmail.com
2	Ж.Наранжав	ИТХ-ын н/б/дарга	Төслийн үйл ажиллагааны баримт бичиг бүрдүүлэх, мэдээлэл өгөх, тэмдэглэл хөтлөх	88714040 jav6212@gmail.com
3	Б.Эрдэнэчулуун	Иргэний төлөөлөл	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд үйл ажиллагааны фото болон видео зураг авалт хийж, баримтжуулах ажил хийх	86180307 Erka_0307@yahoo.com
4	Х.Шинэбаатар	ИТХ-ын тэргүүлэгч	2 удаагийн хяналтын үйл ажиллагааг зохион байгуулах хяналтын болон хэлэлцүүлгийн бичиг баримт, бэлтгэл ажил хангах	89160990
5	Ч.Оюунбаатар	6-р багийн ИНХ-ын дарга		80400030

Төсөл хэрэгжүүлснээр гарсан гол үр дүн, бүтээгдэхүүн, шинэлэг ажил

- Уул уурхайн компаниудын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл авсан үйл явц, түүнд орон нутгаас оролцох оролцоо, эрх, үүргийн талаар хурлын төлөөлөгчид мэдлэгтэй болсон.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын хуулийн дагуу байх ёстой бичиг баримтын бүрдэл, уурхай дээрээ заавал байлгах баримт бичгүүд, тэдгээрийг хэрхэн мөрдөж ажиллах ёстой гэдгээр нь хяналт, үнэлгээний аргаар тодорхойлох чадвартай болсон.
- Төлөөлөгчид үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, компаниудын улсын болон орон нутгийн төсөвт төлдөг татвар, төлбөр, хураамжийн төрөл, хэмжээ, төлөх хугацаа зэргийг мэдэж авсан.
- Хяналт, үнэлгээгээр тухайн компани үйл ажиллагааг хянахад иргэдийн оролцоог хангаж, ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх боломжтой болж, хамтын ажиллагаа сайжирсан.
- Хяналт, үнэлгээний журам, хяналтын картыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталж гаргасан нь цаашид төлөөлөгчид, иргэдийн оролцоог хангасан багаар тухай бүрд хяналт, үнэлгээ хийж **хариуцлагатай, ил тод уул уурхайг хөгжүүлэх** боломж бололцоог бий болгосон.
- Сумын газар нутаг дээрх ашигт малмалын тусгай зөвшөөрөл бүхий компаниудын лицензийн талбайн байршил, тэдгээрийн нөлөөлөлд өртөж болзошгүй малчдын өвөлжөө, хаваржаа, худаг уст цэг, түүх соёлын дурсгалт газрын байршил, тусгай хамгаалалттай газар нутгийн бүс зэрэг мэдээллийг харуулсан **Олборлох салбарын ил тод байдлын мэдээллийн 1:200000 масштабтай зураглал** боловсруулан гаргасан.
- Дээрх зураглалыг гаргаснаар цаашид уул уурхайгаас байгаль орчин болон нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн суурь судалгааг гаргаж бодлого боловсруулан хэрэгжүүлэх үндэслэл болж байгаа нь энэхүү төслийн гол үр дүн гэж сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 12-р сарын 01-ний өдрийн 7-р хуралдаанаас дүгнэлээ.

Сумын нутаг дэвсгэрт геологи, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тавих хяналт, үнэлгээний журам



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 2 дугаар сарын 17 ны өдрийн 36 дугаар
Тогтоолын 1 дүгээр хавсралт

**СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ИТХ-ААС
ТАВИХ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хяналт үнэлгээний зорилт нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүсч болох аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, орон нутгийн оролцоо, ил тод байдлыг хангах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж хамтын ажиллагааг үр дүнтэй байлгахад оршино.
- 1.2. ИТХ-аас хийх хяналт үнэлгээг Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчны холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу явуулна.
- 1.3. Хяналт үнэлгээг уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид туршиж үзсэн хавсралт үнэлгээний картаар хийнэ.
- 1.4. Хяналт, үнэлгээнд сумын нутаг дэвсгэрт геологи уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хамрагдана.
- 1.5. Хяналт үнэлгээнд тухайн багийн иргэдийн оролцоог хангана.
- 1.6. Хяналт үнэлгээний багийг иргэний төлөөллийг оролцуулан ИТХ-ын дарга томилно.

Хоёр. Хяналт, үнэлгээ явуулахад баримтлах зарчим

- 2.1. Хууль, тогтоомжийг эрхэмлэн дээдлэнэ.
- 2.2. Харилцааны ёс зүйг баримтлана.
- 2.3. Багаар ажиллана.
- 2.4. Ил тод, тэгш шударга байна.
- 2.5. Баримт, нотолгоонд тулгуурлана.
- 2.6. Хараат бус байна.
- 2.7. Тодорхой бус гомдол, овог нэр хаяггүй мэдээллээр явуулахгүй.

Гурав. Хяналт үнэлгээний мөрөөр зохиох ажил

- 3.1. Хяналтын үнэлгээний үр дүнг аж ахуйн нэгж, байгууллагын захиралд танилцуулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд мэдээлэл хийнэ.
- 3.2. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлийн улмаас үүссэн хохирлыг холбогдох этгээдээр барагдуулах асуудлыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлж үр дүнг тооцно.
- 3.3. Хяналт үнэлгээний нэгдсэн тайланг уул уурхайн гурван талт хэлэлцүүлэгт мэдээлж иргэдэд нээлттэй ил, тод байлгана.

Дөрөв. Хяналт үнэлгээний багийн үүрэг

- 4.1. Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;
- 4.2. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- 4.3. Хяналтын үр нөлөө болон төлөөлөгчийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах
- 4.4. Хийсэн хяналт үнэлгээгээр илрүүлсэн алдаа зөрчлийн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 4.5. Хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх буюу шилжүүлэх
- 4.6. Хяналт үнэлгээний тайлан материалыг байгууллагын архивт нэгж болгон хадгалуулах
- 4.7. Хяналт үнэлгээг байгууллагын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу үнэлгээний картаар гүйцэтгэнэ.

Тав. Хяналт үнэлгээний багийн эрх

- 5.1. Хяналт үнэлгээ явуулахдаа тухайн нэгжийн удирдлага, ажилтантай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах; алдаа, зөрчлийг арилгуулах талаар ажилчдад шаардлага тавих
- 5.2. Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;
- 5.3. Хөндлөнгийн хяналтын байгууллагад хандан үзлэг, хяналт хийлгэх, заавар зөвлөгөө авах, хамтран ажиллах
- 5.4. Хяналт шалгалт хийхэд холбогдох мэргэжилтнүүдийг татан оролцуулах

Зургаа. Хариуцлага

- 6.1. Хяналт үнэлгээгээр зөрчил гаргасан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авхуулах саналыг мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ.
- 6.2. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад, хүний амь нас хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц байвал орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлж, шийдвэрлүүлнэ.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 4 дүгээр сарын 7 ны өдрийн
36 дугаар Тогтоолын 2 дугаар хавсралт

АШИГЛАЛТЫН ЛИЦЕНЗТЭЙ КОМПАНЫГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ

	Компани дээр байх ёстой, олон нийтэд нээлттэй үзүүлэх үүрэгтэй баримт бичиг, Төлөөлөгчдөд өгөх мэдээлэл	Ашиглах мэдээллийн эх сурвалж	Хяналтын тэмдэглэл
А. Компани кемп дээр очиж үзэх боломжтой баримт бичгүүд, шалгах асуултуудтай холбоотой хуулийн заалтууд			
1.	АМТХ. 25-р зүйлийн 25.1.6. Хайгуулын ажлын явцад БО-ны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай дүгнэлт	Аймгийн МХГ-ийн дүгнэлтийг бодит байдалтай нийцүүлэн харах, актын огноог харах	
2.	АМТХ. 34-р зүйлийн 34.1. Лиценз авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлсөн эсэх	Төлбөрийн баримт огноог харах	
3.	АМТХ. 17-р зүйлийн 17.3.3. Тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газартай давхцаагүй эсэх	Газрын нэрээр асуух, солбицлолыг лавлаж харах	
4.	АМТХ. 17-р зүйлийн 17.4. Лицензийн нийт талбайн хэмжээ 25 га-аас их, 150 га-аас бага байгаа эсэх	Лицензийн гэрчилгээнээс харах	
5.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар	Хуулбар огноог харж лицензийн хугацаандаа байгаа эсэхийг харах	
6.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.2. Батлагдсан техник, эдийн засгийн үндэслэл болон АМГТГ-аар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө	Төлөвлөгөө түүнийг баталсан огноо	
7.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, Нэмэлт тодотгол хийсэн бол нэмэлт тайлан	Үнэлгээ хийсэн компани, огноо	
8.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.4. БОАЖ-аар батлуулсан БОМТөлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө тайлан.	Батлагдсан огноо түүний хэрэгжилт бодит байдал дээр	
9.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.6. Уурхайн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан акт	Шав тэмдэг тавьсан акт болон бодит байдал дээр ямар байгааг үзэх	
10.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.7. Сумын Засаг даргатай байгуулсан ус, газар ашиглах гэрээ	Гэрээ, байгуулсан огноо, хүлээсэн үүргийн биелэлт	
11.	АМТХ. 42-р зүйлийн 42.1. Нутгийн Захиргааны байгууллагатай Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан эсэх. Уг гэрээг олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх	Гэрээ түүний хэрэгжилт, иргэдийн оролцоо хангасан эсэх	
12.	АМТХ. 43-р зүйлийн 43.1. Компанийн нийт ажиллагсад.....үүнээс.....гадаадын иргэд хэд байгаа	90%-аас дээш давсан эсэх түүний төлбөрийг суманд төлсөн эсэх	
13.	АМТХ. 39-р зүйлийн 39.1.9. Тухайн жилийн нөхөн сэргээлтийн зардлын 50%-ийг БОАЖЯ-ны тусгай дансанд хийсэн төлбөрийн баримт, эргүүлэн авсан эсэх	Төлбөрийн баримтын хуулбар огноо харах	
14.	АМТХ. 41-р зүйлийн 41.1.1. Ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлд гэм хор учруулсан бол хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн	Бодит байдал, иргэдийн мэдээлэлтэй харьцуулж нягтлах	
15.	АМТХ. 69-р зүйлийн 39.1.7. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан сөрөг	Бодит байдал Засаг даргад танилцуулсан баримтуудыг үзэх	

	нөлөөлийг тухай бүр бүртгэж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний тайланг сумын Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлсэн баримт бүртгэл	түүнд Засаг даргын өгсөн хариу	
16.	АМТХ. 48-р зүйлийн 48.10. Тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет бус хандивын хэмжээг олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж	Олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж мэдээлсэн, хандив тусламж хэд хэнд өгсөн, ямар дансанд орсон, баталгаажуулсан байдал	
17.	БОНБҮТХ. 18-р зүйлийн 18.4. Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.	БОНБНУ-ний тайлангаас Санал хэрхэн авсан, хэлэлцүүлэгээс ямар санал гарсан тайланд хэрхэн тусгасан байдлыг харна.	
18.	БОНБҮТХ. 14-р зүйлийн 14.1.2. байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах	Хэрэгжилтийг тайлан, түүнийг олон нийтэд хэрхэн танилцуулсантай тулгаж он оноор үзэх	
19.	ГТХ.5-р зүйлийн 51.2. Төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах зөвшөөрөл	Хэрэгжилтийг газар дээр нь нарийвчлан үзэх	
20.	УТХ.30 дугаар зүйл. Ус ашигласны болон бохирдуулсны төлбөр төлсөн баримт жил бүрээр	Төлбөрийн баримт бичиг	
21.	ГХТХ.8-р зүйлийн 8.1.4./ашигт малтмалын ордыг ашиглах үед үржил шимтэй хөрсийг тусгайлан хуулж ашиглах буюу хадгалсан байх	Засаг даргатай байгуулсан газар ашиглах гэрээнд хэрхэн тусгасан бодит байдал	
22.	ГХТХ.32-р зүйлийн 32.8. ажиллагчид болон хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлий, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөө байгаа эсэх, батлуулсан огноо	Төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг үзэх	
23.	БОХТХ.31-р зүйлийн 31.4. байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг ААН, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх	Тусгасан төсвийн зарцуулалт нөхөн сэргээлтийн үр дүнтэй харьцуулан үзэх	
24.	БОХТХ.49-р зүйлийн 48.1. Иргэн ААН, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлнө.	Байгаль хамгаалагч төлбөр тавьсан бол түүнийг төлсөн төлбөрийн баримт огноо	
25.	БОХТХ.55-р зүйлийн 55.2.2. Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан болон зөвшөөрөлгүй агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хог хаягдал, бусад бодис гаргахад нөхөн төлбөр ногдуулна.	Хэтрүүлсэн хог хаягдал, бусад бодис гаргасныг ажиглах, түүний хэтрэлтэд БОУ-ын байцаагчийн хяналт төлбөрийн баримт бичиг	
26.	Ажилчдын эрх ашгийг хамгаалах Үйлдвэрчний эвлэл байдаг эсэх, түүний үйл ажиллагаатай танилцах	Ажилчдаас мэдээлэл авах	
27.	ТХШТХ-ийн 7.2. ААН, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 311 тогтоолын дагуу Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг эсэх, хариуцсан ажилтан байгаа эсэх	Дотоод журам үзэх, ажилтантай уулзах	
28.	ГХТХ. Газрын хэвлийг ашиглах явцад илэрсэн түүх,	Асуулт хариултаар мэдээлэл	

	соёлын онцгой үнэт зүйл, олдворыг зохих байгууллагад мэдэгдсэн	авах	
В. Тухайн компанитай холбоотой мэдээллийг ЗДТГ түүний холбогдох албан тушаалтанд асуулга, асуулт тавих замаар үзэж болох баримт бичгүүд/шалгах асуултууд/			
1.	АМТХ.38-р зүйлийн 38.1.6. БОХ талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх төлөвлөгөөг Засаг даргаар батлуулсан эсэх	Төлөвлөгөөг Засаг дарга баталсан эсэх, хэрэгжилтийг газар дээр нь үзэх	
2.	АМТХ.41-р зүйлийн 41.1.Лиценз эзэмшигч нь үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж, түүх соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид нь нөхөн төлсөн эсэх, тэдгээрийг шилжүүлэн байршуулахтай холбоотой зардлыг хариуцсан эсэх	Нөхөн төлбөр олгосон мэдээлэл, гарын үсэг, иргэдтэй байгуулсан гэрээ,нөхөн олговор олгох зэрэглэл, тогтоосон байдал, үнэлгээ хийсэн эсэх, гарын үсэг, тамга тэмдэг бүхий баримт үзнэ.	
3.	АМТХ.42-р зүйлийн 42.1.Лиценз эзэмшигч нь БОХ, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар гэрээ байгуулсан эсэх	Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт	
4.	АМТХ.48-р зүйлийн 48.10.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет бус хандивын хэмжээг олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж	Хэрхэн мэдээлсэн, хэвлэн тараасан уу, Малчин ажилгүй байгаа хүн,сумын ажилгүйчүүд, ядуучуудад яаж мэдээлсэн мэдэж байгаа эсэх	
5.	БОНБУТХ.9 –р зүйл. БОНБУ-ний Засаг даргад болон БОУ-ын байцаагчид байгаа эсэх	Үнэлгээний хувийг үзэх	
6.	БОНБУТХ.9 –р зүйл.9.12. БОМен-ийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, улсын байцаагч, Засаг даргын хяналт тавьж байгаа байдал	Тодорхой төлөвлөгөөтэй тогтсон хяналт тавьж байна уу. Хяналт хийсэн тэмдэглэл түүний мөрөөр авсан арга хэмжээг баримтаас үзэх	
7.	ГТХ. 55 дугаар зүйлийн 55.5. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцэж, дүгнэсэн баримт	ИТХ-ын тэмдэглэл	
8.	БОХТХ.10-р зүйлийн 10.1. Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ААН, байгууллага нь 2 жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	2 жил тутамд хийгдсэн тайлан түүний баталгаажуулалт	
9.	БОХТХ.17-р зүйлийн 2.4. нутаг дэвгэрийнхээ ААН, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харъяалал харгалзахгүйгээр хянаVVV.лт тавьж, орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, хортой нөлөөллийг түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	Засаг даргын үүргийн биелэлтийг сонсох	
10.	БОХТХ.17-р зүйлийн 2.6. 17.2.6.ААН,байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах	Хэрэгжилтийн тайлан мэдээлэл	
11.	БОХТХ.18-р зүйлийн 1.3..Байгаль орчныг хамгаалах талаархи Засаг даргын ажлын тайлан сонсох	БИНХ-аас асуух баримт авах	
12.	БОХТХ.18-р зүйлийн 2.2.нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж, орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах	Багийн засаг даргаас асуух, тайлан баримтыг авч үзэх	

Үнэлгээ хийсэн:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 2 дүгээр сарын 4 ны өдрийн
36 дугаар Тогтоолын 3 дугаар хавсралт

ХАЙГУУЛЫН ЛИЦЕНЗТЭЙ КОМПАНИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ

Өлзийт сум


Компани дээр байх ёстой, нийтэд нээлттэй баримт бичиг	Үнэлгээнд ашиглах мэдээллийн эх сурвалж	Хяналтын тэмдэглэл
А. Компанийн кепм дээр очиж үзэх боломжтой баримт бичгүүд/шалгах асуултуудтай холбоотой хуулийн заалтууд		
1 АМТХ. 19 дүгээр зүйлийн 19.4. Лиценз авах хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх эсэх, түүнд ИТХ хугацаандаа санал өгсөн эсэх буюу лиценз нь хуулийн дагуу олгогдсон эсэх	ИТХ- д албан бичиг ирсэн, хариу өгсөн огноог бичиг хэргийн хөтөлгөөнөөс харах	
2 АМТХ. 17 дүгээр зүйлийн 17.4. Лицензийн нийт талбайн хэмжээ 25 га-аас их, 150 га-аас их биш байгаа эсэх	Лицензийн гэрчилгээнээс бодит байдлыг хэмжиж үзэх	
3 АМТХ. 34 дүгээр зүйлийн 34.1. Хайгуулын лиценз авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан лицензийн төлбөрөө төлсөн баримт	Төлбөрийн баримт үзэх	
4 АМТХ. 19 дүгээр зүйлийн 19.8. Хайгуулын лицензийн хугацаа: хэд дэх жилхэд дэх сунгалттай байгаа ²⁰	Лицензийн гэрчилгээ, хуулбараас үзэх	
5 АМТХ. 35 дугаар зүйлийн 35.3.1. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хуулбар	Хуулбар	
6 АМТХ. 35 дугаар зүйлийн 35.2.2. Засаг даргаар батлуулсан жил бүрийн БО-ны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлан	Тайлангийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж төлөвлөгөөтэй тулгаж харах	
7 АМТХ. 35 дугаар зүйлийн 35.2.3. АМГТГ болон МХЕГ-аар хянуулсан хайгуулын ажлын төлөвлөгөө, урд жилийн тайлан	Ажлын төлөвлөгөөний хянуулсан огноо	
8 АМТХ. 38 дугаар зүйлийн 38.1.8. БО-ыг нөхөн сэргээхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сумын Засаг даргын тусгай санд байршуулсан баримт, нөхөн сэргээлт хийж буцааж дэнчинг авсан эсэх	Жил бүрийн баримтыг үзэх	
9 АМТХ. 41 дүгээр зүйлийн 41.1. Хайгуулын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн	Баримтуудыг үзэх, асуулт тавиж хариулт авах, кейс дээр жишээ авч хариулт авах	
10 АМТХ. 42 дугаар зүйлийн 42.1. Нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажилласан байдал	Гэрээг үзэх, Иргэд, ИНБ-ын оролцоог хангасан байдал	
11 АМТХ. 48 дугаар зүйлийн 48.10. Тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет бус хандивын хэмжээний тайлан, түүнийг олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж	Тайлагнасан эсэх, Таилагнасан хэлбэр	
12 АМТХ. 35 дугаар зүйлийн 35.3.7. Сумын засаг даргаас газар, ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулсан эсэх	Газар ус ашиглах гэрээ хийгдсэн огноо. Усны төлбөр тогтоосон дүгнэлтийн хамт	
13 АМТХ. Хайгуулын ажлын явцад нөхөн сэргээлт хийсэн эсэх, түүнийг хүлээж авсан дүгнэлт, түүнд иргэдийн төлөөллийг оролцуулсан эсэх	Нөхөн сэргээлт хүлээн авсан комиссын акт, нутгийн иргэдээс хэн хэн байна	
14 ТХШТХ-ийн 7.2. Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 311 тогтоолын дагуу Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам	Дотоод журам үзэх, ажилтантай уулзах	

	батлуулан мөрдөж ажилладаг эсэх хариуцсан ажилтан байгаа эсэх		
В. Тухайн компанитай холбоотой холбогдол мэдээллийг Засаг дарга болон холбогдох албан тушаалтанд асуулга, асуулт тавих замаар шалгах асуултууд			
1	АМТХ. 19 дүгээр зүйлийн 19.4.Аймгийн Засаг даргад хүсэлт ирснээс хойш 30 хоногийн дотор хүргүүлсэн албан хариу өгсөн байдал	ЗДТГ-ын ирсэн явсан бичгийн хөтөлгөө болон хурлын тэмдэглэлээс харах	
2	АМТХ. 38 дугаар зүйлийн 38.1.6. БОХ талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулсан эсэх	Төлөвлөгөөг үзэх түүнийг Засаг дарга баталсан эсэх, түүний хэрэгжилтийг газар дээр нь үзэх	
3	АМТХ. 41 дүгээр зүйлийн 41.1. Лиценз эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцсан эсэх	Нөхөн олговор олгосон мэдээлэл гарын үсэг, иргэдтэй байгуулсан гэрээ, зэрэглэл тогтоосон байдал, үнэлгээ хийсэн байдлыг биежүүлсэн эсэх, гарын үсэг тамга тэмдэг бүхий баримт бичгүүдийг үзнэ	
4	БОНБҮТХ. 9 дүгээр зүйлийн 9.12. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинэжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа байдал	Хяналт хийсэн тэмдэглэл, түүний мөрөөр авсан арга хэмжээг бичиг баримтаас үзэх	
5	БОНБҮТХ. 8 дугаар зүйлийн 8.4.8. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл	БОНБҮ-ний тайлангаас үзэх	
6	ГТХ. 55 дугаар зүйлийн 55.5. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны ИТХ-аар хэлэлцэж, дүгнэсэн баримт	ИТХ-ын хуралдааны тэмдэглэл	
	Дүгнэлт:		

Үнэлгээ хийсэн:

Төсөлд зөвлөхийн гүйцэтгэсэн үүрэг, өгсөн чиглэл

- Төсөл хэрэгжүүлж эхлэхийн өмнө зөвлөмж, чиглэл өгсөн.
- ИТХ-ын төлөөлөгч нарт хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх арга зүйн сургалт хийж, олборлох салбарын хууль тогтоомжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, суурь мэдлэгтэй болгосон.
- Төсөл хэрэгжүүлэх хугацаанд тогтмол зөвлөгөө, чиглэл өгч ажилласан.
- Хяналт, үнэлгээ хийх тусгай аргачлал, олборлох салбарын хууль тогтоомж бүхий гарын авлагаар хүн бүрийг хангасан.



Уул уурхайн компаниудын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл авах дараалал

